

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +24
Шөнө +10

УЛС ТӨР

Ц.ЭЛБЭГДОРЖ: СОНГУУЛЬДАА
ИДЭВХТЭЙ ОРОЛЦООРОЙ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

СОНГУУЛИЙН ХАР ПИАР АРАЙ
ДЭНДИЭЭ

V нүүрт

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Юун цэцэрлэгт хүрээлэн, хар зах юм биш үү

Э.ТУУЛ

Улс үндэстэн болгон өөрийн гэсэн цэцэрлэгт хүрээлэнтэй байдаг. Тэр ч бүү хэл нэг хотод нэлээд хэдээрээ байх нь бий. Бүр хот нь тэр чигээрээ цэцэрлэгт хүрээлэн шиг байдаг. Цэцэрлэгт хүрээлэнд нь очиход яг л диважингийн нэгээхэн хэсэгт зочилсон юм шиг санагддаг. Цэцгийн хүлэмж, архитектурын гайхалтай шийдлүүд, усан оргилуур, рестораны төгөл, хүлэмж, спортын цогцолбор, тоглоомын газрууд, амьтны хүрээлэн тэр байтугай саун амралтын газартай гээд цогц байдаг. Урлаг соёл, спортын арга хэмжээ, шоу үзүүлбэрүүд ч тасрахгүй. Өөр өөрийн онцлогоороо дэлхийд танигдсан. Тэнд нь очиж үзэх гэсэн жуулчдын хөл тасардаггүй. Тэгвэл үүний нэгэн адилаар Улаанбаатар хотод дэлхийн хотуудын жишгээр иргэдээ амарч зугаалж, чөлөөт цагаа зөв, аятай тухтай өнгөрөөж байх газартай болгож, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан.

Үргэлжлэл нь III нүүрт

ХЯТАД

НҮҮРСНЭЭС ТАТГАЛЗАХ НЬ ТОДОРХОЙ БАЙНА

Н.ПУНЦАГБОЛД

Дэлхий нийтээрээ ногоон хөгжил, ногоон ирээдүйн төлөө зорьж эхлээд байна. Тэр зорилгодоо зарим нь хүрэх дөхөөд, барианд орох ч болчихож. Харин манай улс ногоон хөгжил, ногоон ирээдүйн талаар одоохондоо зөвхөн ярьж л байна. Дээрээс нь манай ихэнх хүмүүс ногоон хөгжил гэдгийг ганцхан мод тарих гээд ойлгочихсон л тууж яваа. Яг үнэндээ ногоон хөгжил гэдэг ганцхан мод тарих биш, байгаль орчноо хайрлаж хамгаалах, эрчим хүчээ хэмнэх, эх дэлхийгээ энэрэх, сэргээгдэх эрчим хүч ашиглах гээд олон талт ажил юм. Бүр олон талаас нь ярьж бичвэл их зүйлийг нурших хэрэгтэй болно. Харин энгийнээр ойлговол бид дэлхийн дулаарлыг бий болгож байгаа буруу зуршил бүхнээсээ салах ёстой аж. Тэгвэл БНХАУ тэр яриад байгаа ногоон хөгжил гэдгийг чинь дэлхий нийтэд



үлгэрлэхээр хэмжээнд хүргэчихэж. Дэлхийд ялгарч буй нүүрсстөрөгчийн давхар ислийн 30 хувийг Хятад улс дангаараа гаргадаг. Дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой 20 хотын 16 нь Хятадад байгаа гэсэн ч тоо баримт бий. Бээжин хотын агаарын бохирдол ямар хэмжээнд хүрчихээд байгааг дэлхий нийт харж л байгаа. Мөн Ази тивийн нийт хорт утаа, агаарын бохирдлын 80 хувийг хятадууд үйлдвэрлэдэг гэсэн тоо баримт байгаа юм. Тиймээс ч хятадууд агаарын бохирдол, байгаль орчны өөрчлөлттэй

тууштай тэмцэж, ногоон хөгжилд анхаарлаа хандуулж эхэлсэн. Энэ ч утгаараа нүүрсний хэрэглээнээс татгалзахаар эрс шийдэж, бүхэл бүтэн зорилготой хөтөлбөрүүдийг дэвшүүлээд ажиллаж байна. Угаасаа агаарын бохирдол ихэсч байгаа нь юуны өмнө нүүрсний хэрэглээтэй салшгүй холбоотой. Цаашлаад машины утаа энэ тэр гээд олон хүчин зүйл байгаа л байх. Гэхдээ л нүүрснээс татгалзаж байж л Хятад улсын өмнөө тавьсан ногоон хөгжил, ногоон ирээдүйд хүрч чадах нь ойлгомжтой. Дэлхийн хүн

амын зургааны нэг нь амьдардаг Хятад улс дэлхийн нүүрсний хэрэглээнээ тал хувийг эзэлдэг гэсэн тооцоо бий. Гэхдээ сүүлийн жилүүдэд нүүрсний хэрэглээг эрс бууруулж, цаашлаад бүр татгалзах хүртэл зорилго тавиад байгаа. Хятадууд 2020 он гэхэд нүүрснээс татгалзана. Үгүй 2030 он гэхэд татгалзана гэсэн янз бүрийн тоо яваад байгаа. Тэгвэл Хятад улс 2020 он гэхэд эхний зорилгдоо хүрч, 2030 он гэхэд нүүрснээс бүрэн татгалзах нь тодорхой юм байна.

Үргэлжлэл нь III нүүрт

Монгол Улсын Улаанбаатар хот дахь Энэтхэгийн Элчин Сайдын Яам

Энэтхэгийн Гадаад Явдлын Яамны Хөрөнгө оруулалт ба Технологи Дэмжих Салбар

“ЭНЭТХЭГТЭЙ БИЗНЕС ХИЙХ НЬ”
арга хэлжээ Улаанбаатар дахь Энэтхэг Улсын ЭСЯ Монголын Бизнес Мэдээллийн Бааз (МБМБ)-Бизнесийн Сүлжээтэй хамтран 2016 оны 6 сарын 16 (нүрвэ гараг)-ны 17.00-20.00 цагт Галакси Тауэр дахь “Экзикотив Экселэнс” Төв буюу ЕЕИВС (www.eeibcmongolia.com)-д зохион байгуулна.

ХӨТӨЛБӨР:

“Нээж үг хэлэх: Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд;
“Энэтхэг-Монголын Эдийн засгийн харилцаа” – Улаанбаатар дахь Энэтхэгийн Элчин Сайдын Яамны Худалдааны төлөөлөгч Ноён Рави Шанкер Гоел;
“Монголын Бизнесийн Мэдээллийн Бааз (МБМБ) хэрхэн яаж Энэтхэгтэй хийх бизнесийг дэмжих бэ” – МБМБ-г Үүсгэн байгуулагч, захирал Ноён И. Сэр-Од;
“Энэтхэгт хийх Монголын экспорт, Монгол дахь Энэтхэгийн хөрөнгө оруулалтын боломж, хамтарсан төслүүдийн өнөөдөр ба хэтийн төлөв” – Монголын Экспортлогчдын Холбооны Ерөнхийлөгч Др Д.Галсандорж;

“Энэтхэг-Монголын хоорондын Тээвэр Зуучлал: Болонж, Сул Тал, Сорилт” – Монголын Тээвэр Зуучлалын Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүн Ноён Ө. Гэрэлмаа.
Оролцогчдод хөнгөн зууш, ундаагаар үйлчилнэ.
Оролцохыг хүсэгчид tsendsuren.b@eeibcmongolia.com хаягаар болон 77106611, 77109911 утсаар холбогдож 2016 оны 6 сарын 15-ны 17:00-н цагаас өмнө бүртгүүлнэ үү.
Бүртгүүлэхдээ оролцох компанийн нэр, албан тушаал, оролцох хүний овог нэр, харилцах утас болон и-мэйлээ өгнө үү. ЕЕИВС-н Уулзалтын өрөө хязгаарлагдмал зайтай учраас “эхэлж ирсэнд, эхэлж үйлчилнэ” зарчмын дагуу үйлчилнэ.

ӨӨР ӨНЦӨГ

ХЭН Ч АМЛАЖ ЧАДНА, ХИЙСЭН НЬ Л ЧУХАЛ

Э.МӨНХ

Монгол Улс сонгуулиар ид амьсгалж, нэр дэвшигчид тулаанд ороод буй. Энэ удаагийн Нийслэлийн ИТХ-ын сонгуульд оролцохоор 11 нам, хоёр эвсэл, 19 бие даагч нийт 333 нэр дэвшигч нийслэлийн Сонгуулийн хороонд бичиг баримтаа хүргүүлснээс хуулийн дагуу шаардлага хангасан гэж нийслэлийн Сонгуулийн хорооноос үзээд, есөн намын 238 нэр дэвшигчийг бүртгэж тогтоол гаргасан. Үүнд, АН, МАН, МАХН-аас тус бүр 45, Иргэний хөдөлгөөний намаас 41, ХҮН-аас 25, БНН-аас 21, Монгол консерватив намаас найм, Хөгжлийн хөтөлбөр намаас тав, МУНН-аас гурван хүн нэр дэвшиж буй. Мөн бие даагчид байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Ийм л өрсөлдөөн тэдний дунд явагдаж байна. Харин хэн нь илүү бодитой ажил хийж, мөрийн хөтөлбөрөө биелүүлдэг болохыг бид хэдийнээс мэддэг болсон. Энэ удаад ч тэдний мөрийн хөтөлбөрийг харахад тиймэрхүү л дүр зураг ажиглагдаж байгаа юм.

Хэн нь хийгээд, хэд нь яриад суугаад байсныг бид мэднэ шүү

Нам тус бүр мөрийн хөтөлбөрөө нийслэлийн Сонгуулийн хороонд хүргүүлснийг бид мэднэ. Тэгвэл МАН “Хэчнээн өндөр байшин барьж, өргөн зам тавиад нийгэм

бүхмидалтай, ядууралтай байхад хүмүүс аз жаргалтай байж байж чадахгүй. Тиймээс бид “Аз жаргалтай хот” гэдэг шинэ үзэл баримтлал гаргаж тавьж байгаа. Маш олон хүний үзэл бодлыг сонсч, тэднийг нэгтгэж, тэдний үзэл санаанаас үзэл баримтлал гаргасан нь энэ. Хүн их олон зүйл хүсдэг. Тэр олон хүсэл нь эцсийн дүндээ аз жаргалыг л эрэлхийлж байдаг.

нийслэлийн толгойд сууж байхдаа зай завсар үлдэлгүй хотын газрыг зарж, нийслэлийг нэгмөсөн унагачихсан байсан гэхэд хилсдэхгүй биз. Гэтэл тэд “Нарийн яривал Э.Бат-Үүлийн хийсэн гээд оноо аваад байгаа ажлууд бүгд биднийг ажиллаж байхад эхэлсэн. Замуудын зурга төсөв, тооцоо судалгаа бид л хийсэн. Харамсалтай нь бидэнд мөнгө байгаагүй.



“Аз жаргалтай хот” гэдэг нэр томъёог бид ч бодоод олчихсон юм биш. Олон улсад “Happy city” гэдэг нэр томъёо байдаг. Бас эд их мөнгөтэй байлаа. Их мөнгөөр косметик засвар сайн хийлээ” хэмээн мөрийн хөтөлбөрөө тайлбарлажээ. Тэднийхээр бол косметик засвар хийгээгүй, ундуй сундуй, шороонд дарагдаж, утаан дундаас нэгнээ олж хархгүй, хөрс нь тэр чигтээ бохирчихсон, борог амьдралтай хотод л хүмүүс аз жаргалтай сайхан амьдарна гэж бодсон бололтой. Харин ч МАН-ын дөрвөн Засаг дарга

Тухайн үед бонд босгож чадсан бол хийчих л байсан” хэмээн гоншигнож байгаа нь үнэхээр өрөвдөлтэй. МАН-ын дөрвөн Засаг дарга хотоо хөгжүүлж гэж санаа тавьсан юм бол яагаад бонд босгочихож болоогүй юм бэ. Яагаад хүн хийсний дараа сэтгэж, хийсэн ажлыг нь булаалцалддаг юм бэ гэсэн бодол өөрийн эрхгүй төрж байгаа биз дээ. Бас “Бүх айлыг амины орон сууцтай болгож, төвийн дулаан, цэвэр, бохир усыг нь холбоод өгнө гэсэн.

Үргэлжлэл нь II нүүрт

Хонг Конг нислэг

5th Anniversary

ХААН банк				Худалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1966.00	1974.00	ФУНТ	2748.00	2831.00	АМ.ДОЛЛАР	1962.00	1975.00
ЕВРО	2197.00	2250.00	РУБЛЬ	28.20	32.00	ЕВРО	2190.00	2249.00
ИЕН	18.34	18.80	ЮАНЬ	297.00	300.00	ИЕН	18.28	18.82
						ФУНТ	2755.00	2823.00
						РУБЛЬ	28.98	31.45
						ЮАНЬ	296.30	300.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

ӨӨР ӨНЦӨГ

Л.Цандэлэг нарыг намын гишүүнчлэлээс хасчээ

ХЭН Ч АМЛАЖ ЧАДНА, ИЙСЭН НЬ Л ЧУХАЛ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

АН-ын дарга З.Энхболд энэ сарын 13-нд намын даргын хувиар нэр бүхий гишүүдийг намын гишүүнчлэлээс хасах тухай тогтоол гаргажээ. Тодруулбал, АН-ын гишүүн атлаа өөр намын нэр дээр болон бие даан нэр дэвшсэн, эс бөгөөс намынхаа дүрмийн эсрэг үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий гишүүдийг намын гишүүнчлэлээс хасахаар болсон аж. “Шим” группийн Ерөнхийлөгч Л.Цандэлэг намаас итгэл хүлээж УИХ-д нэр дэвших эрхээ авч чадаагүйн төлөө намын дотоод үйл явдлыг олон нийтэд дэлгэж, улмаар МАН-ын нөлөө бүхий улстөрчдийг илтэд дэмжиж, АН-ын гишүүний үүргээ умартаж эхэлсэн учраас түүнийг намын гишүүнчлэлээс хасчээ. Мөн АН-ын гишүүн атлаа Иргэний хөдөлгөөн гэгч намаас Дархан-Уул аймагт нэр дэвшсэн ХХАА-н дэд сайд асан Х.Золжаргал, мөн Б.Мөнхболор, Н.Самит, Ч.Бямбаа, Т.Хасбаатар нарын зургаан гишүүнээ намын гишүүнчлэлээс чөлөөлсөн байна. Мөн эдгээр нэр дэвшигчдийг УИХ-ын болон нийслэлийн ИТХ-д нэр дэвшсэн ч дэмжихгүй байхыг намын гишүүддээ уриалжээ.

Хэрэгжсэн нь хаана байна. Зүгээр л хүмүүсийн мөрөөдөл дээр тоглосон болохоос ямар ч шинжлэх ухаанд суурилагагүй, тооцоо судалгаагүй амлалт байсан. Хот нягтаршил сайтай байж үр ашигтай байдаг юм. Гадагшаа биш дээшээ нягтрах ёстой гэсэн үг. Талын нэг тарчихвал шугам сүлжээнээс эхлээд зардлыг нь дийлэхгүй. Үүнийг одоогийн хотын удирдлага ойлгодоггүй” гэж байгаа нь хотыг хөгжүүлэх бус харин ч хумих бодлого баримталж байгаа нь илэрхий. Дээрх тайлбарыг нийслэлийн МАН-ын удирдлага ярьсанд бүр ч их гайхаж байна. Мөн бусад намын мөрийн хөтөлбөрийг харахад ч өнгөрсөн дөрвөн жилд аль хэдийнэ хийгээд, хэрэгжүүлээд эхэлчихсэн ажлуудыг мөрийн хөтөлбөртөө багтааж, өглөө босоод ирэхэд л үлгэрийн юм шиг болгочихсон байх амлалтуудыг мөрийн хөтөлбөртөө шингээжээ. ХҮН-ынхан гэхэд л нийслэлийн төвлөрөл, ажилгүйдлийг бууруулж, хүрээлэн буй орчны бохирдлыг арилгаж, эрүүл цэвэр орчныг бүрдүүлнэ, тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай нийгмийн үйлчилгээг үзүүлнэ, дэд бүтэц, орон сууцны асуудлыг шийдвэрлэнэ гэх зэрэг асуудлыг мөрийн хөтөлбөртөө багтаажээ. Өнгөрсөн дөрвөн жилд эдгээр ажлуудыг хийгээд эхэлчихсэн гэдгийг тэд мэдээгүй байна гэж байхгүй. Тэгэхээр нийслэлийн АН-ынхан голыг нь олоод, зөв бодлогоор ажлаа залж явна гээд дүгнэхчид буруудахгүй байх. Тиймээс ч тэд 2016-2020 онд “5А” мөрийн хөтөлбөрийнхөө үргэлжлэл болгон “5+” мөрийн хөтөлбөртэй энэ сонгуульд оролцож байгаа. Тэдний гол зорилго бол эхлүүлсэн ажлаа үргэлжлүүлэх, үр дүнг нь үзэхийг зорьж байгаа. Тэд

өнгөрсөн дөрвөн жил Гэр хорооллын дахин төлөвлөлтийг эхлүүлж, иргэд хөрс нь бохирдсон хашааны газраа орон сууцаар сольчихоод өнөөдөр сэтгэл амар, аз жаргалтай амьдарч байна. “Сайн хашаа” хөтөлбөрийн буянаар дассан сурсан газартаа, гадаа жорлонд бие засахгүй, хананаасаа халуун усаа аваад амар жимэр аж төрөх боломж бүрдчихээд байна. Энхэл донхолгүй, элэг бөөрний байр солигдчихгүй толь шиг замаар түгжрэлгүй явдаг болсныг нийслэлчүүд бүгд мэднэ. Цэцэг, зүлэгтэй сайхан орчинд амар тухлах боломжтой болсон. Хамгийн их асуудал дагуулж, хаалганаас хаалганд оочерлож, аргаа барахаар танил талаа арын хаалгаддаг байсан төрийн үйлчилгээг эмхэнд нь оруулж, харин хаалга, авлига, хээл хахуульгүй болгож чадсан. Захирамж нэрээр наймаалцаж байсан газрыг иргэддээ хүргэж, эдүгээ олон хүн цахимаар газартай болчихлоо. Олон айл, цаашлаад олон иргэнд хүрсэн энэ мэт ажлуудыг тэд л хийж чадсан гэдэгтэй нийслэлчүүд нэг их санал зөрөхгүй нь мэдэж. Ер нь ч тэгээд хүнд хүсэл сэтгэл байвал хүрэхгүй оргил, хийж чадахгүй ажил гэж байдаггүйг тэд л бидэнд харууллаа. Одоо ч энэ ажлынх нь үргэлжлэлийг нийслэлчүүд хүсч, хүлээж байна. Олон айл хашаагаа халуун устай орон сууцаар солихыг хүлээж байна. Тэд өөр хүчин гарч ирээд өнгөрсөн дөрвөн жил хийсэн ажлууд үргэлжлэхгүй байх вий гэсэн айдастай байгаа нь үнэн. Тийм ч болохоороо нийслэлчүүд Э.Бат-Үүлээ багаар нь дахиулах нь дамжиггүй.

Муу санаа эзнээ
отно гэдэг
байх аа

Сонгуулийн сурталчилгаа
эхэлснээс хойш муу муухай пиар

...Ер нь ч тэгээд хүнд хүсэл сэтгэл байвал хүрэхгүй оргил, хийж чадахгүй ажил гэж байдаггүйг тэд л бидэнд харууллаа. Одоо ч энэ ажлынх нь үргэлжлэлийг нийслэлчүүд хүсч, хүлээж байна. Олон айл хашаагаа халуун устай орон сууцаар солихыг хүлээж байна. Тэд өөр хүчин гарч ирээд өнгөрсөн дөрвөн жил хийсэн ажлууд үргэлжлэхгүй байх вий гэсэн айдастай байгаа нь үнэн. Тийм ч болохоороо нийслэлчүүд Э.Бат-Үүлээ багаар нь дахиулах нь дамжиггүй...

олширч, нэгнээ өдөөн хатгадаг, нэр төрийг нь гутаах зэрэг үйлдлүүд ихэслээ. Тухайлбал, “Монгол хүний төлөө их бүтээн байгуулалт 2020” гэсэн АН-ын сурталчилгааны самбарыг юу ч үгүй урж тасдсан зураг цахим ертөнцөөр цацагдсан. Аль намын хэн гэж үнэнч фэн нь



БИД ХАМТДАА ЗҮТГЭНЭ ХӨГЖИНЭ

урсныг мэдэхгүй. Ганц АН ч биш иргэдийн нүдэнд ил харагдаж буй сурталчилгааны самбар ээлж дараалан урагдаж эхэллээ. Тиймээс энэ мэтээр хүний сурталчилгааны самбарыг урж тасдаж буй иргэдийн үйлдэлд цагдаагийн байгууллагаас хариуцлага тооцохоор болж. Мөн сурталчилгааны самбарыг урж буй хүмүүсийн талаархи мэдээллийг холбогдох газарт нь өгөхийг ч сануулж байна. Үүнээс гадна нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны айл, өрхүүдэд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлийн сонгуулийн сурталчилгааны материал дунд өрсөлдөгч намын ухуулагч нар мөнгө хийж тараасан тохиолдол гарсныг сурталчилгааны штабаас нь мэдээлж, сэрэмжлүүлэг гаргасан байна билээ. Энэ асуудлын талаар тус хорооны иргэн Гантөмөр мэдээлсэн байдаг. Тэрбээр “Өглөөний 10:00 цагт хотын дарга Э.Бат-Үүлийн сонгуулийн сурталчилгааны материалыг барьсан этгээдүүд мөрийн хөтөлбөр дунд мөнгө хийж, гэрт авчирч өгсөн. Зөвхөн манайд төдийгүй олон айл, өрхөд Э.Бат-Үүлийн нэрийг барьж мөнгө тараасан байхыг

үгүйсгэхгүй” хэмээн байгаа юм. Угтаа бол Э.Бат-Үүл нь НИТХ-ын сонгуульд Баянзүрх дүүрэгт бус Хан-Уул дүүргийн 36 дугаар тойрогт нэр дэвшиж байгаа. Нэрийг нь ашигласан нь иргэдийг төөрөгдүүлээд зогсохгүй сонгуулийн хууль тогтоомжийг бүдүүлгээр зөрчсөн, зохион байгуулалттай увайгүй үйл ажиллагаа гэдгийг Нийслэлийн АН-ын сонгуулийн штабаас хариуцлагатайгаар мэдэгдэхийн зэрэгцээ энэ асуудлыг шалгуулахаар цагдаа, Сонгууль зохион байгуулах төрийн байгууллагад албан ёсоор хандаад байгаа гэсэн. Тун удахгүй үнэн мөнийг нь тогтоож, холбогдох этгээдүүдэд хариуцлага тооцно гэж найдаж байгаа бөгөөд ийм төрлийн явуулгуй өдөөн хатгалгад хууртахгүй байхыг сэрэмжлүүлжээ. Түүнчлэн Улаанбаатарын хөгжлийг урагшуулах их бүтээн байгуулалтыг ухраах гэсэн бусармаг оролдлогоо нэн даруй зогсоож, хуулийн хүрээнд шударгаар өрсөлдөхийг уриалсан. Эцэст нь хэлэхэд хэн нь хийгээд, хэд нь яриад суугаад биднийг бид мэднэ шүү дээ. Ер нь ч муу санаа эзнээ отно гэдэг мэргэн ардын маань үг байдгийг энэ дашрамд сануулчихъя.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 88873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Хувьцааг хууль зөрчин олгож байна гэв

Х.НАРАНЦАЦРАЛ

Иргэдэд олгосон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааны 30 хувийг Засгийн газар худалдаж авах асуудлыг эсэргүүцэн өчигдөр Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос /ҮЦАЭХ/ мэдээлэл хийсэн юм. Тэд эсэргүүцлээ гурван үндсэн шалтгаанаар тайлбарлав. Тодруулбал, Хувьцааны 30 хувийг худалдах үйл явцыг арилжааны банкаар хийж буй нь хууль зөрчсөн хэрэг. Хуулийн дагуу брокер, диллерийн компаниар дамжуулах хэрэгтэй гэв. Засгийн газар иргэдийн хувьцааг худалдаж авахад 1.65 их наяд төгрөгийн

бондоор босгох мэдээлэл бий. Ингэхдээ хөрөнгийн зах зээл гэх их айлын хууль дүрмийг шууд зөрчин, арилжааны банкыг илт дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна гэж тэд шүүмжиллээ. Учир нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар аливаа компанийн хувьцаа гаргах асуудлыг үнэт цаас борлуулах тусгай зөвшөөрөлтэй буюу брокер, диллерийн компаниар л хийх ёстой гэжээ. Энэ ч үүднээс өнгөрсөн хугацаанд 1072 ширхэг хувьцаа эзэмшсэн 700 мянга гаруй хүн брокер, диллерийн компанид данс нээлгэсэн байжээ. Гэтэл энэ хуулийг Засгийн газар өөрөө зөрчин, арилжааны банкуудаар дамжуулах болсон гэлээ. Энэ үеэр ҮЦАЭХ-

ны удирдах зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр “Хувьцааг үнэт цаасны зохицуулалттай зах зээлд хийдэг зүйл. Хөрөнгийн зах зээл гэдэг өөрийн гэсэн хууль, дүрмээр зохицуулагддаг. Гэтэл энэ зах зээлийг төр засгаас дэмжихгүй мөртлөө улс төрийн зорилгоор бүү самраачээ гэж хүсмээр байна” гэлээ. Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрхзүйн статусыг тодорхой болгож, үнэт цаасны зохицуулалттай зах зээл, СЗХ-нд бүртгүүлэх, Иргэдэд олгосон гээд байгаа хувьцааг зөвхөн Засгийн газар худалдаж авах бус тухайн иргэн өөрөө захиран зарцуулах эрхийг нээж өгөх гэсэн гурван асуудлыг тавьж байсан юм.

Ц.Элбэгдорж: Сонгуульдаа идэвхтэй оролцоорой



Монгол Улс, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өчигдрөөс эхлэн энэ сарын 16 хүртэл Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад ажлын айлчлал хийхээр өчигдөр мордило. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Мьянмар Улсын Ерөнхийлөгч Тин Чяу-тай албан ёсны хэлэлцээ хийж, Төрийн зөвлөх бөгөөд Гадаад хэргийн сайд Аунг Сан Сү Чий, Сангийн сайд Кяу Вин, Эрдэс баялаг, байгаль орчин хамгаалах сайд Он Вин, Төв банкны захирагч У Кяв Кяв Маунг нарыг тус тус хүлээн авч уулзана.


Тэгвэл төрийн тэргүүн явахаасаа өмнө УИХ-ын сонгуульд төлөөллөө сонгох хариуцлагатай цаг үед сонголтоо зөв хийхийг нийт иргэддээ хандан уриалсан юм. Тэрбээр, “Таны сонголт ирэх дөрвөн жилд Монгол Улс бүхэлдээ мөн аймаг нийслэл бүртээ ямар бодлого, ямар үнэт зүйлийг баримталж ажиллахад шийдвэрлэх нөлөөтэй байх болно. Таны бүрэн эрх олгосон хүн л тэнд ажиллана. Таныг төлөөлж чухал чухал шийдвэр гаргахад оролцоно. Энэ сонгуулиар бүрэн эрх нь эхлэх УИХ, ИТХ-ын бүрэлдэхүүнд

юу ус агаар шиг дутагдаж байгааг сонгогч Та сайн мэднэ. Монголын төрд хуулийг дээдэлдэг, өндөр ёс зүйтэй, хариуцлага хүлээх чадвартай элч төлөөлөгч нэн хэрэгтэй болсныг Та сайн харж байгаа. Ард түмний нийтлэг эрх ашигт, яг Таны хүсэн хүлээж байгаа тэр үнэт эрх ашигт үйлчлэх тийм гишүүн бас тийм төлөөлөгчийг Та олж сонгож чадна гэдэгт би эргэлзэхгүй байна. Иргэд сонголтоо үргэлж итгэж хийдэг. Харин Таны сонгосон хүмүүсээс Таны итгэлийг эвдсэн бол Та хариуцлага тооцох эрхтэй. Тэр алтан цаг мөч, тэр ховор боломж одоо л Таны мэдэлд орж ирж байна. Би өмнө нь иргэдийг өөртөө илүү боломж, илүү оролцоо, харин төрөөс илүү хариуцлага, илүү ёс зүй шаардаарай гэж хэлж байсан. Одоо ч энэ үгээ давтаж байна. Сонгогч Таны сонголтоо хийх хугацаа өдөр өдрөөр ойртож байна. Сонгуулийн хугацаа ч урт биш. Та энэ зургадугаар сарын 29-ний өдөр саналаа өгнө. Иймээс сонгуулийн бүх үед сонгуульдаа идэвхтэй оролцоорой. Нэр дэвшигч бүр хуулиа чанд мөрдөж, өөрсдийн нэр төр, хүний ёс журмыг эрхэмлэж шударга өрсөлдөөрэй. Эвийг хичээж, бүтээлч үйлс, бодлого зорилгоо урьтал болгоорой” хэмээн уриалав.

Үйлдвэрлэгчид өнөөдөр төв талбайд үзэсгэлэнгээ гаргана

Дэлхийн санхүүгийн зах зээлээс Монгол Улс өөрсдөө том хэмжээний санхүүжилтийг 2012 онд босгож байсан билээ. Тодруулбал, таван тэрбум ам.долларын санхүүжилт босгох эрх авч, улмаар 1.5 тэрбумыг босгосон нь Чингис бонд. Уг бондын мөнгөөр дэд бүтэц, үйлдвэржилт, эрчим хүч, жижиг дунд үйлдвэрлэлийн төсөл, мөн улсын хэмжээний 20 гаруй том төслийг санхүүжүүлсэн байдаг. Өнгөрөгч долоо хоногийн пүрэв гарагт Хөгжлийн банк болон Аж үйлдвэрийн яам бусад байгууллагууд Бондоор санхүүжсэн бүтээн байгуулалт сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, энэ бондоос мөнгө авч санхүүжсэн том төслүүдийг танилцуулсан юм. Тэгвэл өнөөдөр Чингис бондын хөрөнгөөр санхүүжсэн төсөл хөтөлбөрүүдийг дэмжих зорилгоор "Чингис бонд үндэсний үйлдвэрлэл" үзэсгэлэн худалдааг 10.00-18.00 цагийн хооронд Чингисийн талбайд зохион байгуулахаар болжээ. Үзэсгэлэнд Чингис бондоос санхүүжсэн 300 орчим төсөл хөтөлбөр, үндэсний ААН, байгууллагууд оролцох аж. Үзэсгэлэн худалдааны үеэр иргэд энэ төсөл хэрхэн үр дүнтэй өгсөн талаар мэдээлэл авч, мөн компаниудын үйл ажиллагаа үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнтэй нэгбүрчлэн танилцах боломж бүрдэх юм байна.

ҮЗЭЛ БОДОЛ



ХЯТАД

НҮҮРСНЭЭС ТАТГАЛЗАХ НЬ ТОДОРХОЙ БАЙНА

Дугаарын **60** мөр

Юун цэцэрлэгт хүрээлэн, хар зах юм биш үү

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Өнөөдөр хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа эрүүл агаарт зөв боловсон өнгөрүүлэх цор ганц газар нь тэр болсон. Шарилжаар дүүрсэн, дэд бүтэцгүй байсан тэрхүү газар эрх мэдэлтнүүдийн хараанд өртөөгүйн ачаар цэцэрлэгт хүрээлэн болж, өнгө нэмсэн нь тэр. Нийт 110 мянга гаруй мод сөөг, олон улсын стандартад нийцсэн Монголын анхны 5.5 км дугуйн болон гүйлт, цанын зам, сагсан бөмбөг, холбөмбөг, софт теннисийн комплекс спортын талбай, хүүхдийн тоглоомын талбай, газрын усан оргилуур зэрэг олон бүтээн байгуулалтыг өнгөрсөн таван жилийн дотор хийж амжуулахын зэрэгцээ иргэдийн ухамсарт мод, сөөг тарих, ногоон байгууламжийн ач тусыг ойлгуулж чадсаны ачаар Үндэсний цэцэрлэгт хүрээлэн цэвэрс бүрхсэн, ногоон талбар болсон. Ийм цэцэрлэгт хүрээлэнгэй болсон нь сайн хэрэг. Гэвч харамсалтай нь эдүгээ цэцэрлэгт хүрээлэнд дөнгөж хөл тавихад л урдаас хиншүү хярвас ханхалж, хоолны гудамжаар явж байгаа мэт сэтгэгдэл төрнө. Шөнө орой болсон ч хамаагүй хуушуур бууз, шорлог, хорхог, таван цулын шөл, хонины чанасан толгой гээд аль л шингэц муутай, хүнд хоолнуудыг зарахын зэрэгцээ эрүүл ахуйн талаар үг унагаад ч хэрэггүй. Өдөржин шороонд дарагдсан өнгө муутай тэдгээр хоолыг хүүхэд л болсон хойно авах гэж дайрла. Тиймээс ч цэвэрлэх хүрээлэн хоолны үлдэгдэл, хогонд дарагдсан. Үүний зэрэгцээ хэрэгтэй хэрэггүй олон бараа, хүүхэд хураах тоглоом, эрүүл мэндэд хор болохоор хоол зарж, бооцоот, мөрийтэй тоглоом тоглодог газар болж хувирсан байна. Хоёр, гурав, дөрвөрөө сууж жийдэг үхэр тээр шиг дугуй нь ганц тойрохдоо мөнгө төлөхийг эс тооцвол спортлог гэхээсээ мөнгө олох гэсэн ядмаг арга гэж болно. Хүүхэд хураах тоглоомон машины үнэ ч өндөр. Тавхан минут тойроход л 3000 төгрөг. За тэгээд, үндэсний тодотголтой цэцэрлэгт хүрээлэндээ амрах гэж очсон биш ажил хийж олсон хэдэн төгрөгөө шавхахын зэрэгцээ хар захаар тэнэж байгаа юм шиг стресс чирсээр гэртээ харих нь олон болж.

Олны хөлийн газар байж ядаж нэг ч АТМ байхгүй. Бас цэцэрлэгт хүрээлэнгийн эргэн тойронд тор татсан нь эгээ л "шорон" гэлтэй. Мөн сүүлийн үед иргэдээс эд зүйлээ гэссэн, машинныхаа толийг алдчихлаа гэх зэрэг гомдол их ирж байгаа гэсэн. Түүнчлэн дэргэдэх хотхонхын нь иргэд шорлогны утаа, үнэрээс үнэндээ залхаж байгаагаа хэлж байсан юм. Дэлхийн хотуудын дайтай, Азидаа хамгийн том үндэсний хэмжээний цэцэрлэгт хүрээлэн болгоно гэсэн чинь оройдоо Нарантуулынхан шавдаг бохир газар л болон хувирч дээ. Анх байгуулагдахдаа арай ч ийм байгаагүй санагдана. Иргэд нь хотоо хайрлаж, хамгаалж, гар бие оролцож байж л хот хөгжил дэвшилд хүрэх учиртай. Гэтэл энэ тал дээр нийслэлчүүд маш хангалтгүй байна. Өөрсдөө ийм ухамсартай байгаа хэрнээ төр захиргааны байгууллага юм хийхгүй байна гэж шүүмжлэх дуртай. Үнэндээ хийгээд тавьсан зүйлийг нь эвдчихээд юм хийхгүй байна гэж ярих хэрэг байна уу. Нийтийн эзэмшлийн эд зүйлсийн төлөө сэтгэл зовж, түүнийг хайрлаж хамгаалдаг иргэн нийслэлд амьдрах хэрэгтэй юм шиг санагдана. Угтаа бол хөдөлмөрийг үнэлж чаддаггүй хүн л бусдын хөдөлмөрийг устгадаг гэдэг. Тиймээс хүний хөдөлмөрөөр бий болсон зүйлийг хайрладаг, хамгаалдаг сэтгэлгээтэй болох нь хамгийн чухал байна даа. Ингэж чадвал их хотоо эзний ёсоор мэддэг, ирсэн жуулчдад зочны ёсоор хандаж чаддаг "Найрсаг улаанбаатарчууд" болох нь дамжиггүй.

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Бид эндээ Тавантолгойн нүүрсээ булаалдаж суух зуур хамгийн том зах зээл болох Хятад улс нүүрсийг халах ажлаа аль хэдийн 50 хувиас давуулаад явж байна. Бүх бэлтгэл ажил хангагдчихаж, эхнээсээ үр дүнгээ үзэж байгааг харлаа, үзлээ. Өнөөх 1072 хувьцаа, Тавантолгойн өгөөж энэ тэр бол үлгэрийн далай л болж хувирах бололтой. Хятадууд нүүрс авахгүй нь тодорхой болчихвол бид Тавантолгойнхоо нүүрсийг өөрсдөө л ашигладаггүй юм бол дэлхийн зах зээлд гаргадаг хөг өнгөрөх нь. Ердөө л хэдхэн жил нүүрсээр тэвдэж нүүрснээс татгалзаж байгааг тайлбарлах нь зүйтэй байх.

Сэргээгдэх эрчим хүчээр Хятадыг хангана

2014 онд БНХАУ-ын Ерөнхийлөгч Си Жинпинь манай улсад төрийн айлчлал хийх үеэр Монголын 250 сэтгүүлчийг БНХАУ-д очихыг урьсан. Эхний ээлжийн 50 сэтгүүлч өнгөрсөн жил Хятад оронд очиж, тодорхой сэдвийн дагуу мэдээ материал бэлтгэсэн. Тэгвэл энэ удаад Хятадад айлчилсан 50 сэтгүүлч "Ногоон хөгжилд анхаарлаа хандуулья" сэдвийн хүрээнд олон газрын үйл ажиллагаатай танилцаж, Хятад улсын хөгжил дэвшлийг тольдоо. Тэд үнэхээр ногоон ирээдүйг цогцлоон бүтээж чадаж. Хаана сул талбай байна, тэнд мод тарьчихаж. Ногоон хөгжлийн суурь нь мэдээж ногоон байгууламж. Тэгвэл хятадууд сууриа хангалттай тавьсан байна. Харин дараа нь нүүрснээс татгалзах ажлаа эхэлж.

Тэдний хамгийн тэргүүнд шийдвэрлэж байгаа зүйл нь сэргээгдэх эрчим хүч. Бид аяллынхаа хоёр дахь өдөр Тяньжин хотод байрлах "Шин И" компанийн үйл ажиллагаатай танилцсан. Тус компани нь дэлхийн хамгийн том нарны энергийн шилэн хавтан үйлдвэрлэгч гурван том аж ахуйн нэгжийн нэг аж. Тус компанид 15 мянган хүн ажилладаг бөгөөд Малайз улсад нэг том салбартай аж. Тиймдээ ч Тяньжин хотноо асар өргөн уудам талбайг хамарсан нарны эрчим хүч үйлдвэрлэх эко бүсийг байгуулчихаж. 30 мянган га газрыг хамарсан тэрхүү нарны энерги

хуримтлуулах эко бүсийг 1.4 тэрбум юанийн хөрөнгө оруулалтаар бүтээсэн юм байна. Жилдээ 200 сая кВт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалтай. Энэ нь 68 мянган айлыг цахилгаанаар хангах боломжтой гэсэн үг. Дээрээс нь жилдээ 84 мянган тонн нүүрсийг хэмнэх боломжтой болж байгаа ажээ. Өөрөөр хэлбэл, ийм хэмжээний нүүрс түлэхээ болиноо л гэсэн үг. Ингэснээр агаарын бохирдол тодорхой хувиар буурна. Мөн найман жилийн дараа хөрөнгө оруулалтаа нөхөж чадах юм билээ. Энд нэг зүйлийг сануулахад, "Шин И" компани нарны энергийн паркийг зүгээр ч нэг байгуулаад зогсохгүй тэр хавийнхаа байгаль орчинд ч бас анхаарлаа хандуулж байгаа юм билээ.


Тодорхой хэлбэл, шилэн хавтангуудынхаа доор усан сан байгуулж, тэндээ загас үржүүлэхээр төлөвлөж байгаа юм байна. Мөн шилэн хавтангийн дор ус хийж өгснөөр эрчим хүч хуримтлуулах чадвар нь 30 хувиар нэмэгдэх ажээ. Ингээд л байгаль орчныхоо эко системийг ч аварч үлдэх боломжтой. Одоогоор тус нарны энергийн парк 40 сая кВт эрчим хүчийг үйлдвэрлэж, өнгөрсөн гуравдугаар сарын 1-нээс айллуудад өгөөд эхэлчихсэн байгаа юм байна. Энд ганцхан зүйлийг хэлэх хэрэгтэй. Хятад улс 2020 гэхэд томоохон үйлдвэрлэл байхгүй бүхий л бүс нутгаа сэргээгдэх эрчим хүчээр хангах зорилготой байгаа аж. Тэр зорилгодоо ч хангалттай хүрч чадна гэдгийг албаны хүмүүс хэлж байлаа. Зөвхөн нарны энергийг ч биш салхины эрчим хүчийг хэрэглэж байгаа юм билээ. Энэ бол Хятад нүүрснээс татгалзахаар хийж байгаа ажлын ердөө л нэг хэсэг. Энэ мэтээр 20, 30 мянган га талбайг хамарсан нарны энерги цуглуулах паркийг ойрын жилүүдэд маш олноор нь барихаар ч төлөвлөж байгаа юм байна.

Эрчим хүч хэмнэх ч гэсэн нүүрснээс татгалзах бодлогын нэг хэсэг


Аяллын хоёр дахь өдрийн өглөө бид Хятад улсын байгаль хамгаалалт, эрчим хүч хэмнэх группийн үйл ажиллагаатай танилцсан юм. Одоогоор Хятадад байгаа цорын ганц эрчим хүч хэмнэх хамгийн том байгууллага аж. Хятад дахь эрчим хүч хэмнэх байгаль орчныг хамгаалах салбарт шинжлэх ухаан технологийг ашиглаж үйлчилгээ үзүүлдэг хамгийн том групп юм байна. Бүхий л үйл ажиллагаа болоод чадал нь Хятад улсын хэмжээнд тэргүүлж байгаа ажээ. Хятадын 30 гаруй муж хог, гадаадын 40 улсад үйл ажиллагаа явуулдаг, 260 орчим салбартай компани гэж байгаа. Хамгийн гол нь энэ компани эрчим хүчийг хэмнэх бүхий л технологийг Хятадын хэмжээнд нэвтрүүлж байгаа юм билээ. Эрчим хүчний хэмнэлттэй барилгуудыг барих, цаашлаад тийм хотхон, хорооллуудыг ч босгох зорилготой аж. Мөн нүүрсний хийг шууд ашиглаж, эрчим хүч гаргах боломжтой цахилгаан станцийг барьж байгуулахаар төлөвлөгөөгөө гаргачихсан байна билээ. Бид нүүрсээ олборлоод, гал тэргээр зөөгөөд, цахилгаан станцдаа түлээд, эрчим хүч, дулаан гаргаж авч байгаа. Тэгвэл Хятадууд шууд газрын гүн рүү хоолой явуулаад л, хийг нь дамжуулж авдаг станц барих гэж байна. Түүнээс гадна бид Тяньжин хотод Хятадын шинэ Тяньжини эко хотын төлөвлөлттэй танилцсан юм. Тус хот нь Тяньжин Бинхай шинэ дүүргийн бүсэд орших аж. Хятад, Сингапур улсын Засгийн газрын стратеги хамтын ажиллагааны хөтөлбөр, байгалийн баялгийг хэмнэсэн, экологид ээлтэй нийгмийн хөгжлийн нийтлэг шинжилгээ судалгааны хүрээнд хийж байгаа

Байгалийн хийгээр эрчим хүчийг шийднэ

Хятад улсын нүүрснээс татгалзах бодлогын нэгэхэн хэсэг нь байгалийн хийг ашиглах. Манайхан өнөөдөртөө ахуйн хэрэглэнд, хоол унд хийхдээ л газ ашиглаж байгаа. Мөн автомашинд шатахуун маягаар хэрэглэж байна. Тэгвэл Хятад даяар хэрэглээний газыг бүхий л зүйл ашиглаж байгаа юм. Өвөр Монголын Ордос, Бугат, Хөххоттой танилцаж байхад орон сууц болгоны дээр газын баллонууд өрөөстэй байна билээ. Учир нь газар халаалтаа хүртэл шийдээд эхэлчихсэн нь тэр аж. Бид аяллын дөрөв дэх өдөр Өвөрмонголын Ордос хотод очиж, байгалийн хийн үйлдвэртэй танилцсан. Ерөөсөө Ордос хотод одоогоор илэрсэн байгаагийн хийн нөөц нь 44 тэрбум тонн бөгөөд бүх Хятадын нийт нөөцийн 1/3 хувийг эзэлж байгаа аж. Мөн дэлхийн хамгийн том хийн орд Сүрэг хийн ай сав энэ нутагт хүртэл байгаа юм байна. Бидний Ордос хотод айлчлахдаа танилцсан үйлдвэр бол Өвөр Монголын эрчим хүчний хөрөнгө оруулалтын компани. Тус байгууллага газын хийн үйлдвэрлэлээ нэлээд эрчимжүүлж, шинэ шинэ технологийг нэвтрүүлж эхэлж. Өдөртөө 30, 50, 100 мянган тонн газ үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг байгуулж. Тэгэхдээ бүр газрын хийг өрмийн цооногийн амсар дээр нь шингэн болгож шахах боломжтой дэвшилтэд технологийг ашиглаж байгаа юм байна. 30 мянган тонноос бага хэмжээгэйг үйлдвэрлэх бол өрмийн цооногийн амсар дээр нь шахаад, шууд баллонд хийгээд л тээвэрлэдэг аж. Ингэхээр хоолойгоор дамжуулснаас хамаагүй өртөг багатай байдаг юм байна. 600 метр куб хийг нэг метр куб шингэн болгодог аж. Энэ мэтээр газын үйлдвэрлэлийг үнэхээр эрчимжүүлж байна. Газ тээвэрлэх машин, явуулын газ түгээх станц хүртэл нэвтрүүлсэн байсан. Тиймдээ ч айл өрхийн дулааныг хийгээр шийддэг болчихож. Нүүрс шатааж усаа халаадаг байсан бол одоо хий шатаагаад л шийдчихэж байна. Ингэж л нүүрснээс татгалзаж эхэлж. Цаашлаад агаарын бохирдлоо ч хүртэл шийдэж чадаж байгаа юм. Тус газын үйлдвэрийг өнгөрсөн 2015 оны арваннэгдүгээр сард л нээсэн юм байна. Одоогоор туршилтын журмаар ажиллаж байгаа аж. Нэг өрмийн цооног дээр өдөрт 30 мянган тонн хийг хэрэглээний газ болгон хувиргаж байхад л хангалттай ашигтай ажиллана гэж төлөвлөж байгаа юм билээ. Ийм ч учраас Хятадад газын өртөг маш хямд байна. Сардаа нэг айл хоол ундныхаа хэрэглээнд 10-хан юанийн өртөг бүхий газ хэрэглэдэг гэсэн. Ам ангаймаар байгаа биз дээ. Ер нь бол Хятадуудын хэлснээр тус улс 2030 он гэхэд агаарын бохирдлыг бүрэн шийдэж чадах юм билээ. Энэ бол 2030 он гэхэд нүүрснээс бүрэн татгалзана гэсэн үг байх. Тиймээс бидэнд нүүрсээ зарах 10 жил л байна.



Эрчим хүчний хэмнэлттэй эко хорооллын барилгын загвар



68 мянган айлыг цахилгаанаар хангах чадалтай нарны зайн эко парк



УЛС ТӨР

18 дахь жилдээ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины III улирлын захиалга
үргэлжилж байна

Улиралд

44

дугаар

Захиалгын үнэ

15400



Монгол шуудан: 70078977

УБ шуудан: 70127027

Скай пост: 70121294

Түгээмэл шуудан: 70115025

ОНЦЛОХ ХУУДАС

СОНГУУЛИЙН ХАР ПИАР АРАЙ ДЭНДЛЭЭ

Эсрэг тэсрэг байр суурь

**Т.Алтаншагай:
Л.Эрдэнэчимэг
гишүүнтэй
холбогдоход мөнгө
амлаж, 50 саяыг
шилжүүлсэн**



/УИХ-ын сонгуулийн 72 дугаар тойрогт бие даан нэр дэвшигч/

ШШТББ-ын тэргүүн Х.Бат-Ялалт, сэтгүүлч Т.Алтаншагай нар өчигдөр “Хууль

тогтоох байгууллагынхан баталсан хуулиа өөрсдөө зөрчиж байна” гэсэн сэдвээр “Монгол ньюс” мэдээллийн төвд мэдэгдэл хийлээ. Энэ мэдэгдлийн үеэр тэд улстөрчтэй холбоотой нууц бичлэг задлах тухайгаа мэдэгдээд, Архи, тамхины тухай хуулийг санаачилж, батлуулсан УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг Төрийн ордон дахь өөрийн албан өрөөндөө халамцуу байдалтай, ёс бус үг хэрэглэн сууж байгаа бичлэгийг үзүүлсэн юм. Мөн 28 секундийн энэхүү бичлэгийг насан туршийн зээл хэмээн 50 сая төгрөгөөр үнэлэн Х.Бат-Ялалтын дансанд мөнгө шилжүүлсэн баримтыг ч дэлгэсэн юм. Энэ талаар сэтгүүлч Б.Алтаншагай “Энэ сарын 5-ны өдөр надад УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэгийн Төрийн ордон дотор халамцуугаар ёс бус үг хэлж, авирлаж байгаа төрийн түшээгийн ёс зүйд үл нийцэх 26 секундийн бичлэг “Үнэнээ хэлэх мөч” нэврүүлэгтээ оруулаарай. Амжилт хүсье гэсэн бичгийн хамт ирсэн. Тэр бичлэгийг шууд гаргах боломжгүй байсан тул би ШШТББ-ын тэргүүн Х.Бат-Ялалттай зөвлөлдсөн. Тэгээд Л.Эрдэнэчимэг гишүүнтэй холбогдож, бичлэгийн талаар асуухад, мөнгө амлаж, насан туршийн зээл гээд өчигдөр 50 сая төгрөг шилжүүлсэн. Бид одоо энэ мөнгийг нь буцааж өгөх гэж байна. Энэхүү бичлэг Г.Уянга гишүүний утсан дээр хадгалагдсан байсан бөгөөд тэрбээр утсаа алдсанаас үүдэн энэхүү бичлэг алдагдсан байх магадлалтай” гэсэн юм.

... “Энэ сарын 5-ны өдөр надад УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэгийн Төрийн ордон дотор халамцуугаар ёс бус үг хэлж, авирлаж байгаа төрийн түшээгийн ёс зүйд үл нийцэх 26 секундийн бичлэг “Үнэнээ хэлэх мөч” нэврүүлэгтээ оруулаарай....

... “Би Х.Бат-Ялалтад найз нөхдийн журмаар 50 сая төгрөг зээлүүлсэн. Сонгуулийн ажилд хэрэгтэй байна гээд байхаар нь тусалсан боловч эцэст нь намайг унагаах оролдлого хийж байна...



**Л.Эрдэнэчимэг:
Х.Бат-Ялалт
сонгуулийн
ажилдаа хэрэглэнэ
гэж 50 сая төгрөг
зээлсэн**

/УИХ-ын гишүүн, УИХ-ын сонгуулийн Сонгинохайрхан дүүргийн 72 дугаар тойрогт АН-аас нэр дэвшигч/

УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэгийн

Төрийн ордонд ёс зүйгүй аашилж буй бичлэгийг Сонгинохайрхан дүүрэгт нэр дэвшигч, сэтгүүлч Б.Алтаншагай, “Шударга шүүх” ТББ-ын тэргүүн Х.Бат-Ялалт нар олон нийтэд ил болгосон. Тэд Л.Эрдэнэчимэг гишүүнээс авсан гэх 50 сая төгрөгөө хэвлэлийн хурал хийх үеэрээ бэлнээр авч явж байсан бөгөөд мэдээлэл хийснийхээ дараа буцааж өгөхөөр очиход нь Л.Эрдэнэчимэг гишүүн тайлбар хийсэн юм. Тэрбээр “Би Х.Бат-Ялалтад найз нөхдийн журмаар 50 сая төгрөг зээлүүлсэн. Сонгуулийн ажилд хэрэгтэй байна гээд байхаар нь тусалсан боловч эцэст нь намайг унагаах оролдлого хийж байна. Яагаад нэр дэвшиж байгаа эмэгтэйчүүд рүүгээ эрчүүд нь нийлээд дайраад байгаа юм бэ. Зээлсэн мөнгөө барьж ирээд, хэвлэлийнхнийг дуудаж реалити шоу хийж яах гэсэн юм бэ. Яагаад шударгаар өрсөлдөж чаддаггүй юм. Бичлэгийг олон нийтэд ил болгосон Б.Алтаншагай бид хоёр УИХ-ын 72 дугаар тойрогт нэр дэвшч байгаа. Намайг буруутгаад Б.Алтаншагайг сонгож болно. Гэхдээ бид хийсэн зүйлээрээ л өрсөлдөх хэрэгтэй. Ингэж нэгнийгээ доош нь хийж, бөгсийг нь ухах ямар шаардлага байна. Тэр бичлэгийг би үзээгүй. Ямар бичлэг байгааг мэдэхгүй байна” хэмээсэн. Мөн тэрбээр бичлэгийг үзсэнийхээ дараа дэлгэрэнгүй тайлбар хийнэ гэдгээ ч мэдэгдсэн билээ.

Сэтгүүлчийн дүгнэлт

НӨХӨД НОХОД БОЛОХ ЦАГ ГЭЖ ЭНЭ БАЙХ

Э.МӨНХ

Анхны ардчилсан сонгуулиас хойш монголчууд юу эсийг үзэв дээ. Энэ жил бүр ч их үзэх юмтай, ярих сэдэвтэй байх шиг. Сонгуулийн сурталчилгаа эхэлж, ердөө тавхан хоног өнгөрч байхад л нэг нэгнээ намнасан улс төрийн хар PR дүхалзах байтугай бүр цагаандаа гарав. Нэг нэг рүүгээ дайрсан хар мессеж улам ихэсч, үүний хар гайгаар өөрийнхөө цахим хуудсанд ч тавтай тухтай орж чадахаа больж байна. Албан тушаалын төлөө амиа өгөхөөс ч буцахгүй тэмцдэг болох нь эдүгээ бүр ч тод ажиглагдаж эхэллээ. Сонгуульд нэр дэвшүүлэхгүй бол өлсөж үхнэ гэж “айлгах тактик” ашиглаад, адаг сүүлд нь эхнэрээ нэр дэвшүүлээд нэг санаа амарсан нэгэн байхад эр нөхрөө булаацалдаж, чи би-дээ тулсан нь ч бий. Өөр нэг ярианы сэдэв нь төрсөн ах дүүс, худ ургууд, баз хүргэдүүд энэ жилийн сонгуульд өрсөлдөж байгаа нь инээдэм. Гэхдээ гэр бүлийн гишүүд өөр өөр намаас нэр дэвшч, хэн нь ч ялсан хамаагүй нэгийгээ татна гэсэн шог яриа ч газар аваад байна. Энэ юу ч биш. Өрсөлдөгчийнхөө тараах материалд мөнгө хавчуулж, зоосон самбарыг нь урж хуулж байна, цаана чинь. Сонгууль ямар бүх зүйл юм уу, сонгууль мөнх үргэлжлэх юм уу, үгүй л баймаар. Гэтэл эдүгээ архины ширээний ард, халамцаж, хөгжилдөж суухдаа марзагнасан яриаг нууцаар бичээд, сонгуулиар “чулуу болгон” ашигладаг болж. Энэ бол өчигдөр өрнөсөн үйл явдал. Нэг тойрогт нэр дэвшиж байгаа эр, эм хоёр хүний хооронд өрнөсөн энэ асуудал нэг биш нэлээд олон хүнийг чирэх нь тодорхой боллоо. Олон нийтийн сүлжээ гэдэг өөрөө маш хүчтэй хэрэгсэл. Тийм учраас хэн нэгэнтэй холбоотой ноцтой мэдээлэл нэгэнт тархсан бол, тэр өөрөө дараа нь яаж ч асуудлыг залруулаад нэмэргүй л болов уу. Нөгөөтэйгүүр энэ бичлэг гэнэт яагаад олон нийтийн сүлжээгээр ил болсон бэ гэдэг нь асуудал. Бас л сонирхолтой. Тэгэхээр энэ бичлэгийг хийх үед байсан хүмүүс, бичлэг хийсэн утсаа алдчихсан гэж цагдаад мэдүүлсэн Г.Уянга гишүүн, бичлэгийг нэвтрүүлгээр цацаарай гэсэн захидлын эзэн, шантаажилж мөнгө авсан болон шилжүүлсэн хүмүүс гээд бүгдийг нь шалгаж, үнэн мөнгийг нь тогтоох эрх нь хууль хяналтынханд байгаа. Үнэхээр асуудал байгаа бол тэр асуудлыг хууль, хяналтын байгууллага хуулийн дагуу шалгаад, хариуцлага тооцож яагаад болохгүй байх билээ. Үнэндээ энэ заль хэнийх байсан нь сонгогчдод огтхон ч хамаагүй. Халамцсан үедээ эрхэм гишүүн юу ярьсан нь сонин биш. Харин энэ бичлэгээр шантаажилж, мөнгийг нь авчихаад нийтэд цагчихсан тэр хүмүүс л гутамшигтай санагдаж байна. Хамгийн гол нь нут уучихаад бичлэг хийж, хийсэн бичлэгээ бусдад өгч, данс явуулж мөнгө авчихаад олон нийтэд дэлгэж байгаа нь хамгийн гутамшигтай бөгөөд араас “хутгалж чадах” жинхэнэ аюултай хүн гэдгийг харууллаа. Бичлэг хийсэн, бас олон нийтэд зарлаж гаргаж ирсэн гаруудад улс төр, төрийн босго хаагдах ёстой. Үнэндээ сонгуулийн сурталчилгаа бол өөрийнхөө хийсэн ажил болон хийх ажлаа олон нийтэд таниулахад оршдог. Гэтэл манай улстөрчид өрсөлдөгчөөсөө гадна өөр хамааралгүй хэн нэгнийг ч хараар будах тун муу сонгуулийн тактикийг ашиглаад байгаа нь энэ цагт явуургүй болж. Улстөрч болохын тулд мэдээж дардан замаар өгсөхгүй. Гэвч үнэхээр хийж чадаж байгаагаа, эсвэл хүчгүй нэгнийгээ харлуулах улс төрийн бохир тоглоомыг манайхан сүүлийн үед үнэхээр гарамгай хийдэг гэдгээ харуулж байна. Хэнийг ч хэн ч биш болгож чаддаг юм байна. Энэ дайралт эрэгтэй улстөрчид рүү гэхээс илүүтэй эмэгтэй улстөрчид рүү арай л хэтэрхий ирж байна. Х.Бат-Ялалт, Т.Алтаншагай нар өөрсдөө нэр дэвшч байж, өрөөлийг ингэж намнах хэрэг байсан уу. Үнэхээр хийж бүтээе гэж байгаа бол эр хүн шиг өрсөлдөх хэрэгтэй. Эмэгтэйчүүдийг ийм арчаагүй аргаар дарж авах хүртлээ төрийн суудлын төлөө улайрах гэж дээ. Үнэндээ сонгууль мөнх үргэлжлэхгүй. Сонгуулийн дараа сайн нөхөд уулзаж, ярьж хоорч, идэж ууж, илэн далангүй итгэж нөхөрлөж амьдрал өмнөх шигээ л үргэлжлэх нь дамжиггүй. Гэтэл дөрөвхөн жилийн настай эрх мэдлийн төлөө насаараа эрхэмлэх хүн чанараа гээж яанам бэ. Нөхөд ноход болох цаг гэж л энэ байх даа...

ДЭЛХИЙ

“Apple” хиймэл оюун ухаан бүхий “I Phone” бүтээнэ

АНУ-ын ухаалаг гар утасны салбарт тэргүүлэгч “Apple” корпораци хиймэл оюун ухаан бүхий “I Phone” гар утас бүтээх гэнэ. Тодруулбал, хүний хэлсэн өгүүлбэрийг ойлгож, мессэж болгон илгээх чадвартай хиймэл оюун ухаан бүхий технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэхээр болжээ. Ингэснээр тус компани ухаалаг гар утасны салбарт цоо шинэ хувьслыг эхлүүлэхээр болоод байна. Энэ сарын 13-нд Санфранциско хотноо “Apple” корпораци хөгжүүлэлтэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, шинэ технологи, үйлчилгээгээ

танилцуулсан байна. Түүний дотор ухаалаг гар утсанд хэрэглэгдэх хиймэл оюун ухаан бүхий технологи олны анхаарлыг маш ихээр татсан аж. Аль эртнээс судлагдаж байсан энэхүү технологи нь текстийг ойлгож, хариу мессэж автоматаар илгээх чадалтай гэнэ. Түүнчлэн, камераар авсан хүн болон байгалийн юмсын зургийг ангилан автоматаар цомог үүсгэн хадгалахаас гадна бичлэгт засвар хийх чадвартай юм байна. Сүүлийн үед ухаалаг гар утасны бизнесийн салбар дахь өрсөлдөөн ширүүссэн гэж хэлж болно. Үнэ хямд үзүүлэлт

сайтай гар утаснууд зах зээлд нийлүүлэгдэх болсноор энэ жилийн эхний нэг хагаст “I Phone” гар утасны борлуулалт анх удаагаа буурсан үзүүлэлтэй гарсан юм. Тиймээс хэрэглэгчдээ татах, борлуулалтаа нэмэх зорилготойгоор “Apple” компани хиймэл оюун ухааны технологийг нэвтрүүлсэн шинэ программ хангамжаа ирэх намраас эхлэн худалдаанд гаргахаар төлөвлөжээ. Уг технологийг Гүүгл, Майкрософт, фэйсбүүк зэрэг компаниуд ч хөгжүүлж байгаа бөгөөд өрсөлдөөн цаашид улам ширүүсэх хандлагатай байна.

“Севол” хөлгийг татаж гаргах АЖИЛ ЭХЛЭВ

Одоогоос хоёр жилийн өмнө живж, 304 хүний амийг авч одсон “Севол” хөлгийг далайгаас татаж гаргах ажил Өмнөд Солонгос улсад эхэлжээ. 2014 оны дөрөвдүгээр сарын 16-ны өдөр тус улсын зүүн өмнөд эрэгт “Севол” хөлөг живж, 304 хүн нас барсны ихэнх нь ахлах сургуулийн сурагчид байсан нь дэлхий нийтийг цочирдуулж байсан юм. Одоо ч найман хүний цогцос олдоогүй байгаа бөгөөд ор сураггүй болсонд тооцогдож эцэг эх, ар гэрийнхэн нь цогцсыг нь олж, нутаглуулах хүсэл тээсээр хоёр жилийн нүүрийг үзэж байгаа. Тиймээс тус хөлгийг далайн уснаас татаж гаргах ажлын хөргөнгийг Засгийн газраас шийдвэрлэсэн. Энэ ажил эдүгээ биеллээ олж, ням гарагаас эхлэн хөлгийг далайн уснаас татаж гаргах ажил эхэлжээ. 6825 тонн хүнд хөлөг Өмнөд Солонгосын зүүн өмнөд хэсэг дэх Жиндо гэх арлын орчимд гадаргаас 40 метрийн гүнд байрлаж байгаа юм. Албаныхны хэлж буйгаар хөлгийг доороос нь эвдрэл гэмтэлгүйгээр өргөж гаргахаар ажиллаж буй аж. Одоогоор хөлгийн доод хэсэгт 18 өргөгчийг байрлуулсан бөгөөд ирэх сарын сүүлч гэхэд далайгаас бүрэн гаргасан байхаар төлөвлөжээ. Дашрамд дурьдахад, осол болох үед “Севол” хөлөгт нийтдээ 476 хүн зорчиж явсан бөгөөд түүний 325 нь Чезу аралд аялахаар явж байсан 16-17 насны ахлах ангийн сурагчид байсан билээ.

БНАСАУ КИБЕР ДАЙНЫ СУУРИЙГ ТАВИЛАА



Б.ДАВААХҮҮ

БНАСАУ цөмийн зэвсгийн хөгжүүлэлт болон пуужингийн туршилтыг удаа дараа хийж, бус нутгийн аюулгүй байдалд санаатайгаар заналхийлж буйтай холбогдуулан НҮБ-ын Аюулгүйн зөвлөл нэмэлт хориг арга хэмжээ авсан билээ. Түүнчлэн, Сөүл, Пхеньяны харилцаа хурдацмал байдалтай байгаа юм. Тэгвэл ийм хурдацмал нөхцөлд БНСУ дотоод мэдээллээ хакардуулж, хоёр улсын хооронд кибер дайн дэгдэх

суурь тавигдсан тухай “Франц пресс” агентлаг өчигдөр мэдээлсэн байна. Тодруулбал, тус улсын яам, тамгын газрууд болон үндэсний үйлдвэрлэл үйлчилгээний 160 гаруй байгууллагын сүлжээ хакарын халдлагад өртөж, нийтдээ 42 гаруй мянган компьютерээс мэдээлэл хулгайлагджээ. Албаны эх сурвалжуудын мэдээлснээр Хойд Солонгос улсаас Сөүл рүү чиглэсэн хакарын халдлага одоогоос хоёр жилийн өмнө буюу 2014 онд эхэлсэн байна. Гэхдээ мэдээлэл алдагдсан нь гагцхүү

энэ удаагийнх ажээ. Мөн халдсан серверийг нь шалгахад Пхеньяны талаас ирсэн нь батлагджээ. Тодруулбал, өмнө нь 2013 онд Өмнөд Солонгос улсын банк, телевизийн сүлжээ хакарын халдлагад өртөх үед ашигласантай яг адил IP хаягийг ашигласан байна. Халдлагад өртсөн байгууллагуудын дунд гар утасны үйлчилгээний “SK Telecom” компанийн харьяа байгууллагууд, иргэний агаарын тээврийн хамгийн том авиа компани “Корсан Эйр” ч багтаж байгаа юм

байна. Түүнчлэн, цэргийн зориулалттай онгоц хөгжүүлэлтийн төлөвлөгөө, цэргийн армийн бэлтгэлийн бичлэг, Батлан хамгаалах салбартайхолбоотоймэдээлэл, кибер халдлагаас урьдчилсан сэргийлэх зориулалт бүхий чухал интернэт сүлжээний мэдээллийг ч гэсэн энэ удаагийн хакарын халдлагаар БНСУ хулгайд алдсан аж. Одоогоор ямар зорилгоор кибер халдлага үйлдсэн нь тодорхойгүй байна. Гэхдээ зарим шинжээчид “Үндэсний хэмжээний төөрөгдлийг

Майкрософт нийгмийн сүлжээний сайт худалдан авчээ



АНУ-ын инженерийн технологийн Майкрософт компани бизнесийн зориулалттайгаар дэлхийн хамгийн том нийгмийн сүлжээний сайт “LinkedIn”-ыг 26 тэрбум ам.доллаар худалдан авахаар болжээ. “LinkedIn” компани нь бизнесийн чиглэлээр мэргэшсэн дэлхийн хамгийн том нийгмийн сүлжээний сайт бөгөөд 200 гаруй улсын 400 сая гаруй хэрэглэгчтэй ажээ. Тус сайтад бүртгүүлснээр гишүүдийнх нь өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил үйлс, ашигтай бизнесийн

орон зайг харах боломжтойгоос гадна нийтлэг сонирхолтой хүмүүс ихэвчлэн нэгддэг байна. Түүнчлэн ажил хайж буй хүмүүс ихэвчлэн тус сайтыг ашигладаг бөгөөд ажил олгох компаниудын тоо ч эрчимтэй нэмэгдэх болжээ. Харин Майкрософт компанийн хувьд интернэт сүлжээгээр дамжуулан Cloud үйлчилгээг нэвтрүүлж, аж ахуйн нэгж рүү чиглэсэн үйл ажиллагаагаа эрчимжүүлж буй. Тэгвэл тус компанийн CEO Сатя Наделла “Худалдаагаар “LinkedIn” –ий өсөлтийг хурдасгах болно” хэмээн ярьжээ.

Македони марихуаны хэрэглээг хуулиараа зөвшөөрлөө

Македони эмчилгээний зориулалттайгаар марихуан хэрэглэхийг хуулиараа зөвшөөрчээ. Махихуаныг эмчилгээнд хэрэглэхийг зөвшөөрсөн улс Европт 10 гаруйхан байдаг бөгөөд тодорхой тооны эдгэшгүй өвчин туссан хүмүүст л хэрэглэхийг зөвшөөрдөг байна. Македони Эрүүл мэндийн газрын дарга Марижа Дарковска Серафимовскагийн хэлж буйгаар эмч нар хүний сэтгэцэд нөлөөлөх тетрагидроканнабинол бодисын агууламж 0.2 хувиас хэтрэхгүй марихуаныг эмчилгээндээ хэрэглэж болох бөгөөд цаашдаа эмийн сангаар худалдахыг хуулиараа зөвшөөрөх яриа хэлцэл хийгдэж байгаа юм байна. Өнөөдрийг хүртэл Австри, Их Британи, Франц, Герман, Итали, Голланд, Испани зэрэг нийтдээ Европын 13 орон марихуаныг эмчилгээний зориулалтаар хэрэглэхийг хуулиараа хүлээн зөвшөөрсөн байна.

Селена Томес тоглоолтынхоо цөөр үйлджээ

Сун Хе Гю: Би ирээдүйн тал
5 цагийн өмнө
“Asian Box” киноны сувагар байгаа билээ. “Зочид буудлаа”

Чингисийн талбайд “Ub d
5 цагийн өмнө
“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр өнгөрсөн жил анх удаа зохион

Гиннесийн амжилтад бүртг
5 цагийн өмнө
“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр нугараач зэрэг нугарч, “Гиннес”-

Азийн хүүхдүүдийн бүтээл
6 цагийн өмнө
Жил бүр уламжлал болгон зохион 8-14-ний өдрүүдэд Япон улсын Т

Хятад охины дуу
7 цагийн өмнө

“Яг түүн шиг” № 6 Баярцэнгэ
8 цагийн өмнө

Дэлгэрэнгүй мэдээллийг MMINFO.MN сайтаас

ШУУРХАЙ МЭДЭЭ

ЭНЭ ЗУН ДОНОРЫН ТОО ЦӨӨРВӨЛ НӨӨЦ БАГАСАХ ЭРСДЭЛТЭЙ

Н.БАТЗАЯА

Манай улс “Цусны донорны дэлхийн өдөр”-ийг өчигдөр тэмдэглэлээ. Уг өдрийг тохиолдуулан Тусгаар тогтнолын талбайд цусны донорыг сурталчлах, олон нийтэд уриалах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэ үеэр Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал, Анагаах ухааны доктор Н.Эрдэнэбаяраас зарим зүйлийг тодрууллаа.

“Цусны донорын дэлхийн өдөр”-ийн талаар мэдээлэл өгөхгүй юу. Энэ өдрийг тохиолдуулан ямар үйл ажиллагаа зохион байгуулж байна вэ?

Дэлхий нийтээрээ 2004 оноос эхлэн жил бүрийн зургадугаар сарын 14-ний өдрийг “Цусны донорын дэлхийн өдөр” болгон тэмдэглэж байгаа. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн орнууд нэгэн зэрэг энэхүү арга хэмжээг зохион байгуулдаг. Монгол Улсын хувьд Улаанбаатар хотод төдийгүй 21 аймагт нэгэн зэрэг тэмдэглэлээ. “Цусны донорын дэлхийн өдөр” нь цусны доноруудад талархал илэрхийлэх, донорын эгнээг өргөжүүлэх зорилготой. Анх 2004 зохион байгуулагдсанаас хойш дэлхий нийтэд цус цусан бүтээгдэхүүний хангамж 25 хувиар нэмэгдсэн. Манай улсын хувьд 2004 онд 20800 донороос цус цуглуулж байсан бол 2015 онд 30400 болсон. Донорын тоо 30 гаруй хувиар өссөн. Эндээс Монгол Улсын хэмжээнд цус цусан бүтээгдэхүүний хэрэгцээ, шаардлага өндөр байгаа нь харагдаж байгаа болов уу. Цус сэлбэлт үндэсний төвөөс донорын эгнээг

өргөжүүлэхийн тулд олон талт ажлыг зохион байгууллаа. Тухайлбал, Эрүүл мэнд, спортын сайдын тушаалаар сар бүрийн 3-ны өдрийг цусаа бэлэглэх өдөр болгож, өнгөрсөн оны дөрөвдүгээр сараас эхэлж тэмдэглэсэн. Цус бэлэглэх өдөр нь донорын сурталчилгааг тасралтгүй явуулах, ард иргэдэд донорын талаар мэдээлэл өгөхөд чухал нөлөөтэй. Мөн 2016 оноос эхэлж 70-100 удаа цусаа өгсөн доноруудыг “Хүрэл донор”, 100-150 удаа өгсөн бол “Мөнгөн донор”, 150-аас дээш цусаа бэлэглэсэн доноруудыг “Атлан донор” гэж өргөмжлөх болсон. Монгол Улсын хэмжээнд нэг алтан донор бий. 180 удаа цусаа өгсөн Бум-Эрдэнэ гэдэг залуу.

“Донорын тоо 30 мянгад хүрсэн гэлээ. Ихэнх хувийг хэдэн насны хүмүүс эзэлж байна вэ?”

Доноруудын 75 хувийг 35 хүртэлх насны залуус эзэлдэг. Манай улс залуучуудын орон. Дэлхийн олон улсын байгууллагуудаас донорын эгнээнд залуучуудыг илүү нэгдүүлэхийг зөвлөдөг. Манай улсын хүн амын ихэнх хувийг залуучууд бүрдүүлж байгаа нь их боломж юм.

Энэ жил улаанбурхан

өвчин гарсны улмаас 18-30 насны залуучууд вакцинд хамрагдаж, цусаа өгөх боломжгүй болсон. Гэтэл одоо зуны улиралтай золголоо. Зун хүмүүс хөдөө, орон нутаг руу аялал зугаалганд явж, цус өгөх донорын тоо цөөрдөг. Цусны нөөц хэр байгаа вэ. Хүрэлцээтэй хэмжээнд байж чадах уу?

2016 онд улаанбурхан өвчин гарсантай холбогдуулан 18-30 насны залуучуудад дархлаажуулалтын вакцин хийлгэсэн. Вакцинд хамрагдсан залуучууд нэг сарын хугацаанд цусаа өгч болдоггүй. Үүнээс болж өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад цусаа өгсөн хүмүүсийн тоо эрс багассан. Үүнийг манай ард иргэд зөвөөр ойлгож, ялангуяа 30-аас дээш насны донорууд болон урьд нь өгч байсан хүмүүс цусаа өгөөрэй. Мөн залуучууд ч гэсэн вакцин хийлгэснээс хойш сар болсон бол цусаа өгөх боломжтой. Ер нь бид олон зүйлийг бодож төлөвлөдөг. Хэрвээ төлөвлөхгүй бол нөөцгүй болно. Зуны улиралд цусны нөөц багасдаг нь донорын тоо цөөрдөгтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, хүмүүс ихэвчлэн хотоос гарч, хөдөө амрах дуртай байдаг. Бид энэ нөхцөл байдалд тааруулан эртнээс нөөц бэлдэх тал дээр их анхаардаг. Гэхдээ энэ ажлыг хийхийн тулд цусаа бэлэглэж байгаа доноруудын туслацаа маш их хэрэгтэй. Тиймээс донорууд зөвөөр ойлгож, цусаа бэлэглэх шаардлагатай. Одоогийн байдлаар нөөц хангалттай байгаа. Бид эртнээс нөөц бэлдсэн учраас залуусыг вакцинд хамруулсан хугацаанд ямар нэгэн бэрхшээл тохиолдсонгүй. Харин энэ зун донорын тоо

цөөрвөл нөөц багасах эрсдэл бий.

“Манай улсын хэмжээнд цус цусан бүтээгдэхүүн хэрэглэх шаардлагатай хэчнээн хүн байдаг юм бэ?”

Миний өмнө хэлсэн тоонуудыг олон жилийн өмнөх ерөнхий дүр зурагт үндэслэж, тусгай тооцооллоор гаргадаг. Жилээс жилд энэ тоо нэмэгддэг. Тухайлбал, таван жилийн дотор 30 хувиар захирал нэмэгдэнэ гэдэг маш өндөр үзүүлэлт. Цаашид ч гэсэн нэмэгдэх хандлага байна. Би нэг зүйлийг онцолж хэлмээр байна. Нэг хүний өгсөн цус гурван хүний амийг авардаг. Яагаад гэвэл нэг удаа цусаа өгөхөд тухайн хүний цуснаас гурван төрлийн бүтээгдэхүүн гаргаж авдаг. Сийвэн, улаан эс, ялгагч эс гэсэн. Сийвэнгийн бүтээгдэхүүнийг нэг жил хадгалдаг учраас нөөц үүсгэж болно. Улаан эсийг 21-42 хоног хадгалдаг учир тодорхой хэмжээний нөөц үүсгэх боломжтой. Гэтэл ялгагч эсийн бүтээгдэхүүнийг тав хоног л хадгалдаг учраас нөөц үүсгэнэ гэсэн ойлголт байдаггүй. Үүнээс болж өдөр бүр цус авах шаардлага гардаг.

Ялгагч эсийн бүтээгдэхүүний талаар тайлбарлаж өгөхгүй юу?

Ялгагч эс нь цусны бүлэгнэлтийг зохицуулдаг. Цус алдах, аргах хууч үеийн өвчин, төрөлхийн болон олдмол бүлэгнэлтийн эмгэгийн үед хэрэглэдэг. Цусанд амьдрах хугацаа нь богино учраас хадгалах хугацаа бага байдаг юм. Тэгэхээр өдөр бүр цус цуглуулж байж ялгагч эсийн захиалгыг хангах боломжтой. Ийм бүтээгдэхүүн дээр нөөц үүсгэх боломжгүйг ард иргэд ойлгож элдэв тохиолдсонгүй. Харин энэ зун донорын тоо

“Хөдөө, орон нутагт цусаа өгөх боломжтой юу?”

Манай төв нийт 26 салбар төвийг мэргэжил, арга зүйн хувьд удирдаж ажилладаг. 21 аймагт салбар бий. Мөн алслагдсан хоёр дүүрэг, 10 мянгаас дээш хүн амтай гурван суманд салбартай. Аймгуудад Улаанбаатар хоттой харьцуулахад цус цусан бүтээгдэхүүний хэрэгцээ бага. Улаанбаатар хотын хувьд 100 хүнд цус өгөлтийн хэмжээ 15, аймагт тав байдаг. Ер нь улсын хэмжээний дундаж 10. Өөрөөр хэлбэл, одоо хүн амын нэг хувь нь цусаа өгдөг болсон гэсэн үг. Бид 2015 онд маш том амжилт гаргасан. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөдөг 1000 хүнд 1.5 хувьд хүргэх зорилгод хүрсэн. Энэ бол бахархам том амжилт.

Цусны донор хүнд тавигдах шаардлага байдаг. Тэр талаар мэдээлэл өгөхгүй юу?

Цусны донор болохыг хүссэн хүмүүст тодорхой хэмжээний шаардлага тавьдаг. 17-60 настай, 45 кг-аас дээш жинтэй, өөрийнхөө эрүүл гэж бодож байгаа хэн бүхэн цусны донор болох боломжтой. Хэрвээ цусаа өгөхөөр шийдсэн бол урьд өдөр нь биеэ бэлдэх хэрэгтэй. Тухайлбал, зургаан цагаас дээш хугацаанд унтаж, амарсан байх, ердийнхөөсөө илүү шингэн зүйл уух ёстой. Мөн цусаа өгөхөөс гурав хоногийн өмнө согтууруулах ундааны зүйл хэрэглээгүй байх шаардлагатай. Эм тариа 10-14 хоногт хэрэглээгүй байх, өөх тос ихтэй хоол идэхгүй байх, өнгөтэй ундаа, жүүс, сүүтэй цай, сүүн бүтээгдэхүүн хэрэглэхгүй байх хэрэгтэй. Энэ талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн сайтаас харж болно.

Гамшгаас хамгаалах бэлэн байдалд 79 сая төргөг зарцуулна

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүл “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах тухай” захирамж гаргажээ. Захирамжийн дагуу Улаанбаатар хотод Ази-Европын хамтын ажиллагааны чуулга уулзалт зохион байгуулахтай холбогдуулан гамшгаас хамгаалах чиг үүрэг бүхий албад, аж ахуйн нэгж байгууллага, сайн дурын хүн хүчийг татан оролцуулах юм байна. Мөн гамшгаас хамгаалах үүрэг гүйцэтгэгчдэд шаардагдах тусгай зориулалтын хувцас хэрэгслийн бэлэн байдлыг ханган ажиллахаар болжээ. Нийслэлийн гамшгаас хамгаалах албадын салбар төлөвлөгөөнд тодотгол хийж, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, автотехник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, үйл ажиллагаагаа уялдуулан зохион байгуулж ажиллахыг нийслэлийн Онцгой байдлын газарт үүрэг болголоо. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангахад шаардагдах зардал болох 79 сая 500 мянган төгрөгийг нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал харууцсан орлогч Н.Батаад даалгажээ.

Авто тээврийн үндэсний төвийн нэг цэгийн үйлчилгээ байгууллаа

“Авто Худалдааны Цогцолбор”-т Авто Тээврийн Үндэсний Төвийн нэг цэгийн үйлчилгээ байгуулж, нээлтээ хийлээ. Нийт 360 ам метр талбайтай, 26 ажилтантай, 18 үйлчилгээний цонх бүхий тус төвд тав тухтай үйлчилгээний байрыг ашиглалтад оруулж, Авто тээврийн үндэсний төвд хүлээлгэн өглөө. Авто Тээврийн Үндэсний Төвийн энэхүү нэг цэгийн үйлчилгээ нь 18 цонхоор бүртгэл мэдээлэл, татвар, даатгал, нотариатын үйлчилгээг үзүүлэхээс гадна, импорттор орж ирсэн авто тээврийн хэрэгслийг шинээр бүртгэх, авто тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ олгох, авто тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, авто тээврийн хэрэгслийн улсын дугаар гэрчилгээг нөхөн олгох, шинэчлэн солих, авто тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах, явуулын дугаар олгох зэрэг автомашины бичиг баримттай холбоотой бүх үйлчилгээг нэг дор төвлөрүүлсэн байна.

3328 улиасны молцгийг тайрчээ

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба “Ази Европын Мон-Экологи” төвтэй хамтран 2016 оны ногоон байгууламжийн ажлын төлөвлөгөөний дагуу нийслэлийн хэмжээнд дөрвөн бригад гаргаж, 18 маршрутаар улиас модны молцог тайрах ажлыг эхлүүлсэн. Тэгвэл тус ажлын хэрэгжилт 80 хувьтай явагдаж байгаа юм байна. Одоогийн байдлаар нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгт байрлаж буй 3328 модны молцгийг тайрчээ. Мөн тус төвөөс улиасны молцог тайрах шаардлагатай моднуудын байршлын мэдээллийн санг үүсгэж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, албан байгууллагуудад өөрийн эзэмшлийн хашаанд байгаа улиас модны молцогийг тайруулах шаардлагатайг зөвлөсөн албан бичиг хүргүүлжээ. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд улиасны хөвөнг багасгахад хамтран ажилласнаар нийслэлийн иргэдийн эрүүл, цэвэр цэмцгэр, тав тухтай орчинд амьдрах нөхцөл бүрдэх юм.

ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

- МОНГОЛ СУУ УХААНЫ МАНУКОЛ АКАДЕМИ ТББ нь 2016-06-14 нд оноосон нэрээ МОНГОЛ СУУ УХААНЫ АКАДЕМИ болгож өөрчилсөн тул хуучин нэрийг хүчингүйд тооцов.

PHOTO NEWS



БНСУ-ын Инчон хотноо зохион байгуулагдаж буй Аэробик гимнастикийн Дэлхийн аварга шалгаруулах тэлцээнд манай баг тамирчид оролцож байгаа билээ. Өнгөрсөн даваа гаргт 12-14 насны ангилалд манай баг тамирчид БАГИЙН төрөлд өрсөлдсөн бөгөөд финалд VIII байраар шалгарчээ. Тамирчид маань өнөөдөр 16:30 минутад финалд тоглоно.

Азийн хүүхдүүдийн бүтээлээр үзэсгэлэн гаргана

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Азийн хүүхдийн уран бүтээлийн үзэсгэлэн” ирэх наймдугаар сарын 8-14-ний өдрүүдэд Япон улсын Тояма хотод болох гэж байна. Энэ удаагийн үзэсгэлэнг Япон улс, тус улсад суугаа Монгол Улсын Элчин Сайддын яам, Монголын Хүүхдийн уран бүтээх төв хамтран зохион байгуулах юм. Үзэсгэлэнд А4 хэмжээтэй цаасан дээр монгол ахуй, ёс заншлаа

илтгэсэн зургийг зурж ирүүлэх аж. Бүтээлийг энэ сарын 12-ноос долдугаар сарын 8-ны 16:00 цаг хүртэл Хүүхдийн урлан бүтээх төвийн байранд авна. Ирүүлсэн бүтээлүүдээс тодорхой шаардлага хангасан 200 бүтээлийг “Азийн хүүхдийн уран бүтээлийн үзэсгэлэн”-д оролцуулна. Үзэсгэлэнд зөвхөн гар зураг гэлтгүй гар урлалын бүтээл оролцуулах хүсэлтэй байгаагаа Хүүхдийн урлан бүтээх төвийнхөн Япон улсад уламжлаад байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Үер усны аюулаас болгоомжил

Цаг уурын байгууллагаас ирүүлсэн мэдээллээр зургадугаар сард бороо орж буйтай холбогдуулан гол, мөрний усны түвшин олон жилийн дундажтай ойролцоо байх төлөвтэй байна. Гэхдээ энэ сард зарим орсон тунадасны хэмжээнээс шалтгаалан усны түвшин огцом нэмэгдэж гол ус үерлэж, зарим газар үер бууж болзошгүйг анхаарууллаа. Иймд гол, мөрөн болон хуурай сайр, гуу жалга даган нутаглаж буй малчид, ард иргэдийг үер усны аюулаас болгоомжлох, үерийн уснаас хамгаалсан суваг, шуудуу татах, тээврийн хэрэгслийн жолооч нар баталгаатай зам, гарам, гарцаар зорчихыг анхаарууллаа.

ЗАВСАРЛАГА

TORNADO

Oishi

ДАВХАР

УРАМШУУЛАЛ

40%



7575-3535

www.pc-mall.mn

PCmallOfficial